



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН  
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК

# ЧАНАРЫН БОДЛОГО

## ЧАНАРЫН ЗОРИЛГО, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨЛТ

Компани нь чанарын бодлогыг хэрэгжүүлэх чанарын зорилгыг бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний шаардлагыг хангахад үндсэн чиг үүрэг бүхий нэгж, хэсгүүдийн түвшинд тодорхойлж, хэрэгжүүлнэ.

Компани нь чанарын зорилгоо (2021-2024 он) дараах байдлаар тодорхойлж байна.

Үүнд:

1. Тасралтгүй, чанартай, найдвартай ЦЭХ-р хангах нь чанарын гол үзүүлэлт учир төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус тасралтыг бууруулан ашиглалтын түвшинг дээшлүүлж тасралт сааталгүй ажиллана.

2. Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн дагуу засвар үйлчилгээ, үзлэг шалгалтын ажлуудыг зохион байгуулах хяналтын тогтолцоог бүрдүүлж сайжруулна.

3. Хэрэглэгчийн шаардлагыг хангаж, санал хүсэлтийг шийдвэрлэн, сэтгэл ханамжийг 80% – 95% хүртэл дээшлүүлнэ.

4. Үйл ажиллагааны чанарын эрсдэлийн түвшинг 15%-иар бууруулна.

Эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрмийн 1.6.16-д заасны дагуу засвар, шинэчлэлтийн ажилд стандартын шаардлага хангасан, чанарын баталгаатай материал, сэлбэгийг нийлүүлж ашиглах, тогтолцоог бүрдүүлж, чанарын доголдол гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

5. Ажлын байрны соёл 5S системийг тогтмолжуулан эмх цэгцийг сайжруулж, тодорхойгүй байдлыг бууруулна.

6. Кайзен саналын системийг идэвхжүүлэн чанарын сайжруулалтын төлөөх ажилтнуудын идэвхи, оролцоог нэмэгдүүлнэ.

7. Чанарын багийн үйл ажиллагааг нь идэвхжүүлж, тогтмолжуулна;

8. Зураг төслийн инженерүүдийг норм, стандарт, дэвшилтэт технологийн талаар мэдээллээр хангах, сургалт семинарт оролцуулж, зураг төслийн ажилд орчин үеийн дэвшилтэт техник, програм хангамж ашиглана.